

**ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ДЭЭД ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭР,
ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 12 дугаар сарын 16.

Чингис хот

№	Эрхзүйн актын нэр, огноо, дугаар, заалт	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө, холбогдох эрх зүйн актын дагуу хийсэн шинэлэг ажлууд	Тайлбар, хэрэгжилтийн үнэлгээ
А	1	2	3
Нэг. Засгийн газрын тогтоол			
1	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан “тэтгэврийн нөөц санд хөрөнгөд төвлөрүүлэх бүртгэх, хуваарилах байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, хяналт тавих журам” 2025/01/16 06/112	Нийгмийн даатгалын төвлөрсөн орлогын дансанд орсон нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрэн төвлөрүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 1-12 дугаар саруудад 100 хувьтай биелүүлэн ажилласан. 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 74522,93 сая төгрөгийн орлогыг хуримтлуулахаар ажиллаж байна. Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд бүртгэлтэй 1015 ажил олгогчийн тайланг шалгаж хүлээж авч баталгаажуулан, 3784 сайн дурын даатгуулагчийн гэрээ болон ногдуулалтыг тухай бүр нь хийж ажиллаж байна.	100%
2	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “2025 оны төсвийн нарийвчилсан хуваарийг батлах тухай” 01 дүгээр тогтоолоор баталсан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын эрүүл мэндийн даатгалын санд 2025 онд бүрдүүлэх орлогын төлөвлөгөөг Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2025 оны хувь хэмжээг тогтоох тухай” 02 дугаар тогтоол 2025/02/11 01/300	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг сумдын болон газрын байцаагч нарт хуваарилан нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 1-12 дугаар саруудад 100 хувьтай биелүүлэн ажилласан.	100%

3	Засгийн газрын 2023 оны 422 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт, бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох санхүүжүүлэх журам” 2025/03/13 04/550	Засгийн газрын 2023 оны 11 дугаар сарын 29-ний өдрийн 422 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт, бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох санхүүжүүлэх журамд заасны дагуу материалыг 28 хоногийн дотор хүлээн авч магадлагч эмчээр баталгаажуулан олгодог. 2025 оны жилийн эцсийн байдлаар 18 хүнд 560,0 мянган төгрөгийн сувиллын болон унааны зардлыг олгосон байна. Үйлдвэрлэлийн ослын сэргээн засах сувиллын тусламж үйлчилгээний болон протез, ортопедийн зардал төлбөр гараагүй болно.	100%
Хоёр. Монгол улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал,			
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Мэргэшлийн зэрэг олгох тухай” А/57 дугаар тушаал 2025/03/06 03/504	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Мэргэшлийн зэрэг олгох тухай” А/57 дугаар тушаалын дагуу 2025 оны 03 дугаар сарын 01-нээс эхлэн тэтгэврийн тогтоолт олголтын байцаагч Т.Наранчимэг, Баянмөнх сумын байцаагч Ц.Нандинчимэг нарт Мэргэжлийн “Зөвлөх” зэргийн 20 хувийн нэмэгдэл, Захиргаа хяналтын хэлтсийн дарга Н.Цолмонбаяр, Тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн дарга А.Октябрь, тэтгэвэр тэтгэмжийн хяналтын байцаагч А.Урангуа, сайн дурын даатгалын байцаагч Ж.Цэрэннадмид, хамралт орлого шимтгэлийн өр хариуцсан байцаагч Д.Жаргалмаа нарт “Итгэмжит” зөвлөх зэргийн 30 хувийн нэмэгдлийг тус тус олгож байна.	100%
Гурав. Монгол улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан даалгавар			
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 албан даалгавар 2025/03/11 02/529	Тус газар нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу Нийгмийн даатгалын газрын шилэн дансны хэрэгжилтэд улирал бүр хяналт тавин ажиллаж, хийсэн ажлын тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын ДАМГ-т хүргүүлэн ажилладаг. Мөн Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай 03 тоот албан даалгаврын хэрэгжилтийг ханган, тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.	100%
Дөрөв. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол			
1	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 02 дугаар тогтоолоор	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам” –ыг албан	100%

	баталсан “Даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам” 2025/03/13 04/550	хаагчдад танилцуулсан. Манай аймагт үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг сэргээн засах сувиллын байгууллага байхгүй болно.	
2	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.9.8 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих журам” 2025/02/07 06	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны санхүүжилт 10.5 сая төгрөгөөр батлагдсан. Газрын даргын тушаалаар ажлын хэсэг зохион байгуулагдаж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу сонгон шалгаруулалтын зар мэдээг цахим орчинд байршуулсны дагуу ирүүлсэн байгууллагуудын бичиг баримт, танилцуулгаас журмын дагуу шаардлага хангасан “Эндээ хөгжил” ТББ 2025 оны 10 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд сургалтыг амжилттай зохион байгуулсан. Тус сургалтаар гарсан зардалтай холбоотой холбогдох санхүүгийн анхан шатны баримтыг нягтлан, шалгасны үндсэнд 100% төлбөрийг шилжүүлсэн.	100%
Тав. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал			
1	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан “2025 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч албан журмаар даатгуулагч сайн дураар даатгуулагчийн тооны төлөвлөгөө” 2025/01/28 06/213	2025 онд сайн дурын даатгалд шинээр 672 даатгуулагч хамруулж сайн дурын даатгуулагчийн тооны төлөвлөгөө 100 хувь биелүүлэн ажилласан. Нийт 3784 иргэн сайн дурын даатгалд хамрагдсан байна. Үүнээс: - Энгийн сайн дурын даатгуулагч хамрагдсан нийт 1086 бөгөөд шинээр 164 даатгуулагч хамрагдсан. - Сайн дурын даатгалд хамрагдсан малчдын тоо нийт 2285 бөгөөд шинээр 411 малчин хамрагдсан. - 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн даатгалд нийт 313 даатгуулагч хамрагдсанаас шинээр 58 даатгуулагч хамрагдсан. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхийг даатгалд нийт 102 даатгуулагч хамрагдсанаас шинээр 39 даатгуулагч хамрагдаад байна. Нийгмийн даатгалд шинээр 95 ажил олгогчийг хамруулсан. Мөн албан журмын даатгуулагчийн тоог 445-аар нэмэгдүүлэн нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан.	97%
2	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71, 72, 73 дугаар зүйл,	НДЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн 02/138 албан бичгийн дагуу үндсэн хөрөнгө актлах, данснаас хасах саналыг НДЕГ-азарт холбогдох бичиг баримтын хамт хүргүүлсэн. Үүнд: Тоног төхөөрөмж 2.3 сая	100%

	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал 2023 оны А/92 дугаар тушаалаар баталсан Нийгмийн даатгалын байгууллагын эд хөрөнгийн тооллого явуулах журам” 2025/01/30 07/225	төгрөг, тавилга эд хогшил 0.8 сая төгрөг, барилга 0.9 сая төгрөгийн хөрөнгө байна. Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллаж 2025 оны байдлаар 1 удаа “Үндсэн хөрөнгө актлах, данснаас хасах” саналаар хуралдсан байна. НДЕГ-ын 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/707 албан тоотын дагуу ТӨБЗГазрын burtgel.gov.mn цахим хуудсанд 2024 оны эд хөрөнгийн хөдөлгөөн, санхүүгийн жилийн эцсийн тайланг 2025 оны 04 дүгээр сарын 07 нд хугацаанд оруулсан. ТӨБЗГазартай 2024 оны гэрээ дүгнэж 82 хувьтай дүгнүүлсэн, түрээсийн гэрээ байгуулж ажилладаггүй болно.	
3	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/15 дугаар тушаал 2025/02/19 01/372	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт орсон өөрчлөлтийн дагуу нийгмийн даатгалын сангийн зардлыг сан тус бүрээр зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна.	100%
4	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 02 дугаар сарын 19-ний өдрийн “2025 оныг Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бууруулах жил болгон зарлах тухай” А/38 дугаар тушаал 2025/02/20 03/391	Хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 183 ажил олгогчийн 482.3 сая төгрөгийн авлагад дансны хаалт хийн барагдуулаад байна. Нийгмийн даатгалын шимтгэл тайлан авалт, шимтгэл төлөлттэй холбоотой сургалтад 121 аж ахуй нэгж, 95 төсвийн нягтлан бодогчдод цахимаар болон танхимаар сургалт зохион байгуулсан.	100%
5	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийг өрийг барагдуулах жил” болгон зарласантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан “Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө батлах тухай” А/47 дугаар тушаал 2025/02/28 06/499	Нэрэмжит жилийн хүрээнд төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу ажилласан. 2025 оны байдлаар урд оны авлага 1722.7 сая төгрөгөөс 1668.8 сая төгрөг буюу 97 хувийг барагдуулан ажилласан. Урсгал авлага 1250.1 сая төгрөг байгаагаас төсвийн байгууллагын авлага 626.3 сая төгрөг байна. 8 ажил олгогчтой уулзалт зохион байгуулж 852.3 сая төгрөг, 412 ажил олгогчийн дансны зарлагын гүйлгээг хааж үл маргах журмаар 1162.3 сая төгрөгийн авлагыг барагдуулсан. Улирал бүр төсөвт байгууллагын авлагын судалгааг гарган дээд шатны байгууллага, төсвийн захирагч нарт, Төрийн сангийн хэлтэст хүргүүлж хамтран ажилласан. Улмаар төсөв нь байгаа хэдий ч гүйлгээ хийгээгүй тайлангаа удаа дараа хоцроосон 3 төсөвт байгууллагад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийж торгуулийн арга хэмжээ ногдуулсан. 5 нягтлан бодогчид хуулийн дагуу хариуцлага тооцсон. Шүүхийн шийдвэртэй нэр бүхий 7 байгууллагатай холбоотой 104.6 сая төгрөгийн авлагаас 97.7 сая буюу 94 хувийг барагдуулсан. Хэнтий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж авлага барагдуулах ажлын талаар санал солилцсон. 2025 оны жилийн эцэст ажил	100%

		олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулж 950.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарахаар ажиллаж байна. Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны оны эхний үлдэгдэл болох 1225.2 сая төгрөгийн шимтгэлийн өрийг бүрэн барагдуулсан байна. 2025 оны жилийн эцсээр өр авлагагүй байхад анхаарч Төрийн сан, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газруудтай хамтран ажиллаж байна.	
6	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 03 дугаар сарын 11-ний өдрийн “Газрын даргын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/51, 03 дугаар сарын 25-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 2025/03/25 03/667	Тус газар нь 2024 оны 11 дүгээр сарын 06-нд газрын даргын дэргэдэх зөвлөлийг шинэчлэн байгуулсан. 2025 онд даргын дэргэдэх зөвлөл 7 хуралдаж Нийгмийн даатгалын газрын дотоод ажил, хийж хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээг шийдвэрлэн ажилласан. 2025 онд даргын дэргэдэх зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй байна.	100%
7	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/50, Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/49 дугаар тушаал 2025/03/28 01/699	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/26 тоот тушаалаар сумдын байцаагч нарт хоолны мөнгийг 10.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэнтэй холбоотой төсөв 17.06 сая төгрөгөөр нэмэгдэж төсөвт өөрчлөлт орон хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
8	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Үүрэг өгөх тухай” А/64 дугаар тушаал, Нийгмийн даатгалын Улсын ахлах байцаагчийн “Зөрчил арилгах тухай” 2025/03/28 02/700	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газраас тус газарт хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын улсын ахлах байцаагчийн 2025 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 32/00002 тоот албан шаардлагын биелэлтийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Хяналт шалгалтын газарт хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Шалгалтаар илэрсэн 10 тэтгэвэр авагчдад дутуу тооцож олгосон 29.1 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас 2024 оны 12 сарын 27-ний өдөр нөхөн олгож, тэтгэврийг өөрчлөн тогтоож, Тэтгэврийн даатгалын сангаас 5 хүнд илүү тооцож олгосон 47.01 сая төгрөгөөс 3 хүний 4.4 сая төгрөгийг барагдуулж, 2 тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтыг зогсоож 42.5 сая төгрөгийг барагдуулахаар уулзалт зохион байгуулан, хэвийн өндөр насны тэтгэвэр тогтоогдсон 1 хүнтэй график байгуулан тэтгэврээс сар бүр суутгал хийгдэж байна. Баримт бичгийн бүрдэл дутуу 11 хүний тэтгэвэр тогтоолгосон баримтын үндэслэлийг дахин нягталж, 7 хүний холбогдох баримт материалыг бүрэн бүрдүүлж, 3 цэргийн тэтгэвэр авагчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүүний нэхэмжлэлийг НДЕГ-ын СБХОГазарт 2024 оны 12 дугаар сарын 30-ний өдөр хүргүүлсэн. Ажилласан жилээ шүүхээр гаргуулах 1 хүний шүүх хурал 12 сард хуралдахаар товлогдсон байна. Мөн илэрсэн	100%

		зөрчлийг арилгах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна.	
9	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/74 тушаалаар баталсан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө" 2025/03/31 01/721	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны санхүүжилт 10.5 сая төгрөгөөр батлагдсан. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны "Журам батлах тухай" 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу сонгон шалгаруулалтын зар мэдээг цахим орчинд байршуулсан. Зарын дагуу ирүүлсэн байгууллагуудын баримт бичиг, танилцуулгаас журмын дагуу шаардлага хангасан "Эндээ хөгжил" ТББ 2025 оны 10 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд сургалтыг амжилттай зохион байгуулсан. Тус сургалтаар гарсан зардалтай холбоотой холбогдох санхүүгийн анхан шатны баримтыг нягтлан, шалгасны үндсэнд 100% төлбөрийг шилжүүлсэн.	100%
10	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн "Аудитын акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай" А/75 дугаар тушаал 2025/03/31 02/733	Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар нь үйл ажиллагааны 2024 оны санхүүгийн тайлангаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. Төрийн аудитаар албан шаардлага 1, акт 1 тавигдсан бөгөөд акт, албан шаардлагаар өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь барагдуулан биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Төрийн аудитын газарт цахимаар болон цаасаар хүргүүлсэн байна.	100%
11	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/34 дүгээр тушаалаар "Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Ахмадын зөвлөлийн дүрэм", "Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ыг шинэчлэн баталсантай холбогдуулан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх "Ахмадын зөвлөлийн дүрэм" 2025/03/31 03/741	Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр А/04 тушаалаар Цагаан сарын баяраар хүндэтгэл үзүүлж 26 ахмад настанд ахмадын сангаас 1.3 сая төгрөг олгосон байна.	100%
12	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Шинэ залуу манлайлал, санал санаачилга гаргах тухай" А/55 дугаар тушаал 2025/04/08 01/819	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Шинэ залуу манлайлал, санал санаачилга гаргах тухай" А/55 дугаар тушаал, 2025 оны 04 дүгээр сарын 08-ний 01/819 тоот албан бичгийн дагуу Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн А/08 тушаалаар залуучуудын зөвлөлийн комиссыг шинэчлэн байгуулсан. Зөвлөлийн даргаар Б.Баярсайхан, гишүүдээр Б.Цэнгэл, А.Бумдарь, А.Оюун, М.Мөнхбаяр нар томилогдон ажиллаж байна. НДЕГ-ын залуучуудын зөвлөлөөс зохион байгуулсан "Таны санал, бидний ирээдүй" сэдэвт уралдаанд "Лого, уриа" үгийг	90%

		хүргүүлсэн. Мөн Нийгмийн даатгалын газрын ажилд залуучуудын зөвлөл идэвх санаачлагатай оролцож байна.	
13	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 04 дүгээр сарын 23-ны өдрийн “Сургалт зохион байгуулах тухай” А/98 дугаар тушаал 2025/04/24 03/1015	Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын албан бус эдийн засгийг албажуулах төсөлтэй хамтран 2025 оны 04 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд УБ хотод нийгмийн даатгалын албан хаагчдыг чадавхжуулах сургалтад тэтгэврийн байцаагч Хонгорзул, тэтгэмжийн тогтоолт олголтын байцаагч Б.Алтансүвд нар хамрагдсан. Тус сургалтаар мэдээллийн Sicos системийн талаар нэгдсэн ойлголттой болж сумдын байцаагчдыг сургах үүрэг бүхий сургагч багшаар бэлтгэгдсэн. Сургалтын хүрээнд газрын 16 албан хаагчдад Sicos системийн мэдээ мэдээлэл өгөхөөс гадна сумдын 14 байцаагчдад AnyDesk-ээр холбогдож Sicos системтэй холбоотой заавар зөвлөмжийг өгч ажилласан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 02/1146 тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажлын хэсгийн хуралд цахимаар 1 удаа хамрагдаж программ хангамжид гарч байгаа алдаа, хөгжүүлэлт, сайжруулалтын саналыг байцаагч нараас авч холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн.	100%
14	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 04 дүгээр сарын 24-ий өдрийн “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгон гадаад улсад амьдарч байгаа иргэдийг дахин магадлах хяналт шалгалтын удирдамж батлах тухай” А/104 тушаал 2025/04/24 01/1018	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1018 тоот тушаал, 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 01/1136 тоот чиглэл, ЭММТЗөвлөлөөс ирүүлсэн үүрэг даалгаврын дагуу хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийг дахин магадлах, гадаадад байгаа иргэдийн тоо мэдээг үнэн зөв гаргах, дотоодын хяналтыг сайжруулах, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Хөдөлмөрийн чадвар алдалтын улсын дундаж 2.9% байгаа бөгөөд аймгийн хөдөлмөрийн чадвар алдалтын дундаж 3.4%-тай байна. Хэрлэн, Баян-адарга, Баянмөнх, Баян-овоо, Бэрх, Мөрөн сумд улсын хэмжээнээс дээгүүр байгаа тул эхний ээлжид дахин магадлалын хяналт шалгалтын хурлыг хийхээр төлөвлөгөө удирдамж гарган Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн даргаар батлуулан, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн хурлаар хэлэлцэн ажиллаж байна. Хэрлэн сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дахин магадлалын шалгалт 40%-тай явагдаж байна.	100%
15	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ны Улсын их хурлын 2023 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 59 дүгээр тогтоолын хавсралтаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030” А/105 дугаар тушаал 2025/04/24 А/105	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-г удирдлага болгон дэд төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган 2025 оны 06 дугаар сарын 12-нд НДЕГ-ын Захиргаа, удирдлагын газарт хүргүүлэн ажилласан.	100%

16	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн "Аудитын акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх тухай" А/137 дугаар тушаал 2025/05/15 07/1211	Тус газрын 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн Төрийн аудитын шалгалтаар 1-ээс дээш жилийн насжилттай нийт 131.9 сая төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулах албан шаардлага тавигдсанаас 98.0 сая төгрөг буюу 74.30 хувийг барагдуулан ажилласан. Барагдаагүй үлдсэн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагад хариуцагч нас барсан Улсын бүртгэлийн газраас хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа гарахгүй эзэн холбогдогчтой болоогүй өв хүлээн аваагүй, Улсын бүртгэлийн хэлтэс нь 2015 онд шимтгэлийн өртэй байхад татан буулгасан хариуцагчгүй зэрэг авлагууд үлдсэн болно. Төрийн аудитын байгууллага шимтгэлийн авлага барагдуулахад авах ёстой арга хэмжээгээ авч ажилласан тул албан шаардлагыг 100 хувь биелэлттэйгээр дүгнэсэн.	100%
17	Нийгмийн даатгалын шимтгэлийн болон сангийн өр төлбөр барагдуулахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран ажиллах 2025 оны төлөвлөгөө, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нартай хамтран ажиллах үүрэг бүхий "Ажлын хэсэг" байгуулсан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/103 дугаар тушаал 2025/06/02 06/1345	Хэнтий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 419 дүгээр нээлттэй хорих ангитай хамтран ажиллаж шүүхийн шийдвэртэй 116.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаас 109.7 сая төгрөгийг барагдуулаад байна. Хэнтий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай 2 удаагийн уулзалтыг зохион байгуулан авлага барагдуулах ажлын явц, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцон ажилласан.	100%
18	Нийгмийн даатгалын сангийн, нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны дунд хугацааны төсөөллийн саналыг Нийгмийн даатгалын багц хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн А/72 дугаар тушаалаар баталсан "Төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, төсвийн нарийвчилсан хуваарь батлах, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулахад баримтлах журам", "Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах	НДЕГазрын даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 04/1364 тоот Төсвийн төсөл, төсөөллийн санал ирүүлэх тухай тушаалаар Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны дунд хугацааны төсөөллийн саналыг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/72 дугаар тушаалаар баталсан "Төсвийн төсөөлөл, төсөөлөл боловсруулах аргачлал"-ын дагуу боловсруулж, танилцуулгын хамт 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр албан бичгээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.	100%

	аргачлал", "Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах аргачлал" 2025/06/03 04/1364		
19	Төсвийн хуваарь хүргүүлэх тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн "Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" А/154, "Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" А/161 дүгээр тушаал 2025/06/17 01/1480	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/161 тоот тушаалаар нийгмийн даатгалын сангийн зарлагыг 700.0 мянган төгрөгөөр бууруулсан. Үүнд тэтгэврийн даатгалын сангийн ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ 700.0 мянган төгрөгийн нэмэлт өөрчлөлт орсны дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төрийн хэмнэлтийн тухай хуульд заасныг баримтлан төсвийн сахилга батыг ханган ажилласан.	100%
20	Ажил зохион байгуулах тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Хөтөлбөр батлах тухай" А/138 дугаар тушаал 2025/06/18 01/1500	Мэдээллийг засварлах шаардлагатай 4257 ажил олгогчийг хамралт орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч, мэдээлэл технологийн мэргэжилтэн, Бор-өндөр сумын тасгийн нэг цэгийн үйлчилгээний мэргэжилтэн нарт хуваарилан ажилласан. Ажил олгогчийн мэдээллийг Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас татаж, үйл ажиллагаа нь зогссон ажил олгогчийг идэвхгүй төлөвт болгох, нэг ажил олгогч дээр олон бүртгэл үүссэнийг нэгээс бусдыг нь идэвхгүй төлөвт оруулах, эдийн засгийн ангиллыг улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэн үйл ажиллагааны чиглэлийн кодоор засах зэрэг ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.	100%
21	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт (байгууллагын болон сангийн)-д 2025 оны 02 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээг хийж, тоон мэдээ, тайланг үнэн зөв, бодитой гаргаж ирүүлэх талаар тус газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн "Ажил зохион байгуулах тухай" 02/1583 дугаар албан бичиг 2025/07/07 02/1682	Хэнтий аймгийн нийгмийн даатгалын газрын 2025 оны хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын сангийн нийт 89 мэдээлэл байршуулахаас 89 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт нийт 95 мэдээлэл байршуулахаас 94 мэдээллийг хугацаанд нь байршуулсан боловч Нийгмийн даатгалын газрын батлагдсан орон тооны мэдээллийн 2 дугаар сарыг хугацаа хоцроон байршуулсан 1 зөрчил гарсан. Зөрчил гарснаас хойш мэдээллийг 31 хоногийн дараа шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Шалгалтын явцад шилэн дансны цахим системд мэдээлэл байршуулах, мэдээлэх үүрэгтэй үйл ажиллагааны нягтлан бодогч, сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэнгүүдэд Шилэн дансны тухай хууль, "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийг баримтлан шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэл өгч ажилласан.	100%

22	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/184 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгаа авах журам" 2025/07/09 05/1726	Ажил олгогч, иргэд, даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгааг "google form" программыг ашиглан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/184 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгаа авах журам"-ын дагуу улирал бүр авч байна. 2025 онд нийт 335 даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авсан. Судалгаагаар дээрх хамрагдсан даатгуулагчдын 75 хувь нь нийгмийн даатгалын үйлчилгээ, мэдээлэл, зөвлөгөө бүрэн авч чадсан гэсэн бол 31.6 хувь нь албан хаагчийн харилцаа хандлагын улмаас үйлчилгээ бүрэн авч чадаагүй гэж хариулсан байна. Албан хаагчдын харилцааны соёлыг 82.9 хувь нь хангалттай сайн гэж үнэлсэн бол 17.1 хувь нь мэдээлэл хангалттай өгөөгүй гэж дүгнэсэн байна.	90%
23	Дотоодын хяналт шалгалтыг сайжруулах тухай 2025/08/19 08/1913	Дээд шатны байгууллагаас ирүүлсэн удирдамж, чиглэлийн дагуу эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг таслан зогсоох ажлын хүрээнд 2024-2025 онд шинээр тогтоосон 290 тэтгэвэр авагчийн тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгасан. Шалгалтад 17 сумын тэтгэврийн хувийн хэрэг, материал хамрагдаж, 28 тэтгэвэр авагчтай холбоотой 9.9 сая төгрөгийг нөхөн төлүүлэх, 16 тэтгэвэр авагчтай холбоотой 7.2 сая төгрөгийг нөхөн олгохоор, нийт 17.1 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлэн ажилласан.	100%
24	"Итгэлцлийн аян"-ыг зохион байгуулах тухай 2025/09/12 А/244	Хэнтий аймгийн хэмжээнд 2025 оны 08 дугаар сарын 31-ний байдлаар нийт 483 байгууллагын 1538.5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өртэй байснаас аяны хүрээнд 301 байгууллагын 722.6 сая төгрөг буюу 47 хувийг барагдуулсан. Аяны хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өртэй ажил олгогчийн гүйцэтгэх удирдлага /захирал/-тай уулзалт зохион байгуулж шимтгэлийн өрийн дүнгийн 10 хувиас багагүй хэмжээгээр төлж барагдуулсан тохиолдолд тэдний гаргасан хүсэлтийн дагуу 6 сар хүртэлх хугацаатай өр төлөх нарийвчилсан хуваарь, тэмдэглэл, гэрээ үйлдэн баталгаажуулах ажлаар 182.2 сая төгрөгийн шимтгэлийн өртэй нийт 12 байгууллагатай шинээр гэрээ хийж 10 хувиас багагүй буюу 38.4 сая төгрөгийн шимтгэлийн өрийг барагдуулсан.	100%
25	Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2025 онд хийсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дүнг Газрын даргын зөвлөлийн өргөтгөсөн хурал, бусад ажил хэргийн уулзалтуудад тус тус танилцуулж, зөрчлийг дахин гаргахгүй байх тухай анхааруулж ажиллах 2025/09/25 01/2374	Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч нар 2025 оны 04 дүгээр сарын 18-25-ны өдрүүдэд хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтаар 127 даатгуулагчид илүү олгосон 70.4 сая төгрөг, 24 даатгуулагчид дутуу олгосон 9.6 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрсэн. Шалгалтын дүн, танилцуулгыг газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулан, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байхад	100%

		анхаарч ажиллахыг байцаагчдад мэдэгдэн, төлбөр зөрчлийг барагдуулах ажлыг зохион байгуулан ажилласан.	
26	Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн сар, улирлын хуваарийг баримтлан батлагдсан төсөвтөө багтаан тухайн сардаа зориулалтын дагуу зарцуулж, өр, авлага үүсгэхгүй байхад онцгой анхаарч, төсвийн сахилга бат, санхүүгийн хариуцлагыг чандлан хангаж ажиллах 2025/09/24 01/2381	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын А/102 тушаалаар байгууллагын үйл ажиллагааны төсөв хуваарилагдан 1,811.9 сая төгрөгөөр батлагдсанаас нийт 8 удаа шинэчлэгдсэн бөгөөд сүүлийн байдлаар НДЕГ-ын даргын А/302 дугаар тушаалаар 1,714.3 мянган төгрөг болж буурч батлагдсан үүнээс 97.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Төсвийн тухай хууль, Төрийн эмнэлтийн тухай хууль, нийгмийн даатгалын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн сар, улирлын хуваарийг баримтлан батлагдсан төсөвтөө багтаан тухайн сардаа зориулалтын дагуу зарцуулж, өр, авлага үүсгэхгүй байхад анхаарч ажиллаж байна.	100%
27	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” 2025/09/25 04/2383	2025 оны байдлаар нийгмийн даатгалд шинээр 74 хамруулах төлөвлөгөөтэйгөөс 128 хувь буюу 95 ажил олгогчийг шинээр хамруулсан. Мөн албан журмын даатгуулагчийн тоог 445-аар нэмэгдүүлэн нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан. 2025 онд сайн дурын даатгалд шинээр 672 даатгуулагч хамруулж сайн дурын даатгуулагчийн тооны төлөвлөгөө 100 хувь биелүүлэн ажилласан. Нийт 3784 иргэн сайн дурын даатгал хамрагдсан байна. Үүнээс 672 даатгуулагч шинээр хамрагдсан. -Энгийн сайн дурын даатгуулагч хамрагдсан нийт 1086 бөгөөд шинээр 164 даатгуулагч - Сайн дурын даатгалд хамрагдсан малчдын тоо нийт 2285 бөгөөд шинээр 411 малчин хамрагдсан. - 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн даатгалд нийт 313 даатгуулагч хамрагдсанаас шинээр 58 даатгуулагч хамрагдсан. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхийг даатгалд нийт 102 даатгуулагч хамрагдсанаас шинээр 39 даатгуулагч хамрагдаад байна. Сайн дурын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор сумд руу хугацаатай албан тоот явуулж 14 хоног тутамд хамралтын мэдээ авч ажиллаж байна. Нийгмийн даатгалын сайн дурын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор сайн дурын даатгалын байцаагчийг худалдааны төв, төвлөрсөн үйлчилгээний газруудаар явуулж сургалт сурталчилгаа хийлгэж мөн Батноров, Бэрх, Батширээт, Бор-Өндөр зэрэг сумд руу ажлын хэсэг томилон сургалт сурталчилгаа хийлгэн ажилласан. Нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлгүүдэд жирэмсэн эхчүүд болон эмнэлгийн эмч ажилчдад нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах, шимтгэлийн 50 хувийг төр болон тэтгэмжийн сангаас төлдөг талаар сургалт хийсэн. Сумын байцаагч нар малчдын зөвлөгөөн, багийн өдөрлөгт, мал тооллого зэрэгт сургалт сурталчилгаа хийж нийгмийн даатгалын үйлчилгээг газар дээр нь шуурхай хүргэн ажилласан. Хөдөлмөр Халамж үйлчилгээний	100%

		газраас оны эхэнд гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг/эхийн судалгааг авч сумд болгоноор жагсаалт гарган хариуцсан байцаагч нарт хуваарилан хамралтыг нэмэгдүүлэн ажилласан.	
28	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасны дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны, олон хүүхэдтэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох иргэдийн тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг цахимаар хүлээн авч тэтгэвэр тогтоох үйл ажиллагааг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс үе шаттайгаар нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах тухай 2025/09/24 02/2419	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Цахим үйлчилгээ нэвтрүүлэх тухай” А/253 дугаар тушаалын дагуу 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох иргэдийн тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг цахимаар хүлээн авах ажлыг зохион байгуулж бүх сумдын байцаагчдыг мэдээллээр ханган, иргэд даатгуулагчдад мэдээлэл хүргэн ажиллаж цахимаар ирсэн 15 хүсэлтийг шуурхай шийдвэрлэж ажилласан.	100%
29	2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар Зөрчлийн тухай хуульд торгох шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх заалт нэмэгдэж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх 2025/10/17 08/2666	Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 08/2666 дугаар зөвлөмжтэй танилцан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Зөвлөмжийг хэрэгжүүлснээс хойш 1 байгууллагыг хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэж, Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.4-т заасны дагуу 250 нэгжээр торгон, зөрчилд оногдуулсан шийтгэлийн хуудсыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор төлсөн тул хуулийн этгээдийн торгуулийн хэмжээг 50 хувиар хөнгөрүүлэн шийдвэрлэсэн байна.	100%
30	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/282 дугаар тушаал 2025/10/20 01/2675	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/282 тоот тушаалаар сангийн нийт зарлагыг 757.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Үүнд тэтгэмжийн даатгалын сангийн зарлагыг 450.0 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлагыг 307.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нэмэлт өөрчлөлт орсны дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төрийн хэмнэлтийн тухай хуульд заасныг баримтлан төсвийн сахилга батыг ханган ажилласан.	100%
31	Засгийн газрын 2023 оны 362 дугаар тогтоолоор баталсан “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм”-ийн 2.6, 2.8 дахь хэсэг, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 10	Засгийн газрын 2023 оны 362 дугаар тогтоолоор баталсан "Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм"-ийн 2.6 , 2.8 дахь хэсэгт заасныг үндэслэн гарсан гишүүдийн оронд маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн НДЕГ-ын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/273 тушаалаар өөрчлөлт оруулсан. Шинээр батлагдсан бүрэлдэхүүнээр	100%

	дугаар сарын 02-ны өдрийн 02/362 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” А/273 дугаар тушаал 2025/10/22 04/2713	маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна.	
32	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/306 дугаар тушаал 2025/11/10 07/2963	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд нөхөн тайлагнасан, цалин, даатгуулагчийн төрлийг өөрчилсөн, устгасан, даатгуулагчийн регистр зэрэг үндсэн мэдээллийг засварласан, нэгтгэсэн байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтаар улсын байцаагчийн актаар болон шүүхийн шийдвэрээр 166.3 сая төгрөгийн цалин сангаас 54 байгууллын 118 даатгуулагчийг нөхөн тайлагнасан, 32 байгууллагын тайланд даатгуулагчийн цалин, төрлийн залруулгыг хийсэн бөгөөд нотлох баримт материал нь үндэслэлтэй, хуулийн дагуу шийдвэрлэгдсэн байна. Тайланг 12 дугаар сарын 01-ний өдөр хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажилласан.	100%
33	Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага өр төлбөр үүсгэхгүй байх”, 70.5-д “Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно” гэж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”-ыг хориглоно, 15.2.7-д “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх” 2025/11/14 01/3015	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/302 дугаар тушаалаар байгууллагын үйл ажиллагааны зардал 1714.3 сая төгрөгөөр өөрчлөгдөн батлагдсан. Цалин хөлсөнд 1330.8 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 172.2 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 43.9 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 12.9 сая төгрөгийг эдийн засгийн ангиллаар зориулалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан.	100%

34	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Хөрөнгө бүртгэх тухай” А/309 дүгээр тушаал 2025/11/28 06/3119	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Хөрөнгө бүртгэх тухай” А/309 дүгээр тушаалын дагуу нийт 5 нэр төрлийн 34 ширхэг 53.1 сая төгрөгийн хөрөнгийг Greenfinance программын “тоног төхөөрөмжийн дансанд” бүртгэж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100%
35	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах тухай” А/343 дугаар тушаал 2025/12/12 06/3276	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах тухай” А/343 дугаар тушаалын дагуу нийт 3.1 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаад байна.	100%

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

Мэдээлэл лавлах албан хаагч:

НЭР	АЛБАН ТУШААЛ	ЦАХИМ ШУУДАН	УТАС	ӨРӨӨНИЙ №
Н.Цолмонбаяр	Захиргаа хяналтын хэлтсийн дарга	tsolmonbayar.n@ndaatgal.mn	88052416	202